



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 5/23

Хэрлэн сум

Шагнаж урамшуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. "Сумын Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, сум, хотын ажлын үр дүнг үнэлэх журам"-ын дагуу сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны 2016 оны тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгээр 1 дүгээр байр эзэлсэн Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрыг 1000000 /нэг сая/ төгрөг, 2 дугаар байр эзэлсэн Батноров сумын Засаг даргын Тамгын газрыг 800000 /найман зуун мянган/ төгрөг, 3 дугаар байр эзэлсэн Норовлин сумын Засаг даргын Тамгын газрыг 600000 /зургаан зуун мянган/ төгрөг, "Батламж"-аар шагнаж урамшуулсугай.

Хоёр. Шагналд зарцуулах 2505000 /хоёр сая таван зуун таван мянган/ төгрөгийг Засаг даргын нөөц сангийн шагнал урамшууллын зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар /Ж.Ганбаатар/-т даалгасугай.

Гурав. Хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн дүнгээр сүүлийн байрууд эзэлсэн сумдын Засаг дарга нарыг ажилдаа дүгнэлт хийж ажиллахыг үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

Аймгийн Засаг даргын 2017 оны
01 дугаар сарын 31 өдрийн 5/123
дугаар захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Зардлын нэр		Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	бүгд
1.	Сумдын Засаг даргын Тамгын газар	1-р байр	1	1000000	1000000
2		2-р байр	1	800000	800000
3		3-р байр	1	600000	600000
4	Өргөмжлөл		3 ширхэг	35000	105000
Нийт үнэ					2505000